

МУИС-ийн докторант Ч. Сэмжидмаа

Монголын төрийн бус байгууллагын чадавхийг сайжруулах асуудалд

Өгүүллийн товч утга: Монгол улсад 1990 оноос хойш Төрийн бус байгууллагууд иргэдийн улс төрийн идэвхийн илэрхийлэл болон шинээр, олноор байгуулагдаж байна. Зарим ТББ-ууд урьд тэр хариуцах ёстой гэж тооцогддог байсан нийгмийн салбаруудад идэвхтэй ажиллан, шинэчлэлийн явцад доголдож эхэлсэн нийгмийн үйлчилгээг нөхөх гэж оролдож байна. Гэвч ихэнх төрийн бус байгууллагууд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цөөхөн хэдэн байгууллага аймаг, хөдөө орон нутагт салбартай, шууд харилцаа холбоотой ажиллаж байна. Олон улсын байгууллагын салбарын үүргийг гүйцэтгэдэг, бусад орны туршлагыг хэрэгжүүлдэг, эсвэл бусад орны байгууллагатай хамтарч ажилладаг ТББ Монголд харьцангуй цөөн байна. Монголын төрийн бус байгууллагууд маш хязгаарлагдмал техникийн болон зохион байгуулалтын чадавхи (мөн туршлага), маш хязгаарлагдмал санхүүгийн нөөц бололцоотой байна. ТББ-ын ихэнх нь санхүүгийн эх сурвалж хомс, эрх зүйн орчин шалтгаалж, ойрын ирээдүйд Засгийн газрын үүрэг, хариуцлагыг хуваалцана гэх итгэл төрүүлэхээргүй байна. Нөгөө талаас Засгийн газрын дээд дунд шатны түшмэдүүдийн иргэний нийгэмтэй хамтран ажиллах мэдлэг, ур чадвар туйлын доогуур бараг анхны мэдэгдэхүүн байхгүй байна. Үүн дээр нийгмийн ялгарал хүчтэй болж, ядуурал нэмэгдэн, нийгэмд маш олон төрлийн эмзэг бүлгийнхэн бий болсон, хувь хүмүүсийн иргэний үүрэг хариуцлагаа ухамсарлах, эрхээ эдлэх асуудал маш тааруу, амиа бодсон үзэл хэт давамгайлж байгаатай уялдаатайгаар олон сөрөг үр дагавар гарч байна. Мөн түүнчлэн ТББ-ын асуудлаар хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажил хязгаарлагдмал, оюутан залуучуудын хийж байгаа бакалавр, магистрийн ажлаас хэтрэхгүй байна. Нөгөөтэйгүүр ТББ-ууд хийсэн ажлын үр дүн, ололт амжилт, сургамжтай асуудал юу байв гэдэг талаар мэдээлэл солилцох, алдаан дээрээ дүгнэлт хийж суралцах, бүх гишүүд дэмжигчдийг оролцуулан ил тод шийдвэр гаргах, ажлын төлөвлөгөө зохион ажил сайжруулах нь бараг байхгүй байна. Иймд төрийн бус байгууллагын чадавхийг бүрдүүлэх төр засагтай үр дүнтэй хамтран ажиллахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Төрийн бус байгууллагын зохион байгуулалт бүтцийг оновчтой болгох, удирдах чадварыг бэхжүүлэх
2. Байгууллагын хөгжих үйл явц, стратегийг оновчтой хийх
3. Техникийн чадавхийг сайжруулах
4. Олон нийтийн эрх үүргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх
5. ТББ-ын мэдээллийн баазтай болж, үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох

Түлхүүр үг. Төрийн бус байгууллага (цаашид ТББ гэж товчилно), иргэний ардчилсан нийгэм, эмзэг бүлэг, Төрийн бус байгууллагын ангилал, ТББ-ын чадавхыг үнэлэх нь.

Монгол улсад 1990 оноос хойш гарч буй улс төрийн өөрчлөлт нь төрийн бус байгууллагын (ТББ) хөгжлийг шинэ шатанд гаргасан юм.

“Төрийн бус байгууллага” гэдэг ойлголтыг улс орнуудад янз бүрээр нэрлэдэг ч үнэндээ өөрийн гэсэн бүтэц, зорилго, үйл ажиллагаатай янз бүрийн төрийн бус байгууллагуудыг хамардаг юм.

Эдүгээ Монгол улсад Төрийн бус байгууллага 4000 гаруй бүртгэгдээд байна. Эднээс 10 хүрэхтэй үгүйтэй нь уламжлалт төрийн бус байгууллага, бусад нь 1990 оноос хойш иргэдийн улс төрийн идэвхийн илэрхийлэл болон шинээр байгуулагдсан юм. Монголын ихэнх төрийн бус байгууллагууд нь тэр бүр тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй ашгийн бус байгууллагууд гэж хэлж болно.

Монгол дахь ТББ-ыг янз бүрээр ангилж болох боловч үйл ажиллагааны нь чиглэлээр¹:

1. Хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах, авьяас чадварыг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн,
2. Жендрийн асуудал, гэр бүлийн сайн сайхны төлөө ажиллаж буй,
3. Боловсрол, шинжлэх ухаан технологийн судалгааг гүнзгийрүүлэхэд тус дөхөм үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг,
4. Соёл урлаг, утга зохиолыг хөгжүүлэх, түүх дурсгалыг хамгаалах зорилго бүхий,
5. Ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлтэй,
6. Нийгмийн халамж эмзэг бүлэг болон тахир дутуу иргэдэд туслах чиглэлээр ,
7. Ахмад настныг халамжлах, хүндэтгэх, тэдний нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэхийн төлөө ажиллаж буй,
8. Хүний эрхийг хамгаалах, иргэний нийгмийг төлөвшүүлэх, ардчилалыг бэхжүүлэх зорилго бүхий,
9. Хууль эрх зүйн чиглэлээр,
10. Экологи, байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд тус дөхөм үзүүлэх чиглэлтэй
11. Бүс нутаг, орон нутгийг хөгжүүлэх зорилгоор ажиллаж буй,
12. Эдийн засаг,ХАА, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ажиллаж буй
13. Мэдээлэл, олон нийтийн хэвлэл мэдээллийг идэвхжүүлэх зорилго бүхий
14. Улс хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дэм үзүүлэх зорилготой,
15. Спорт, аялал, жуулчлалыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх чиглэл бүхий,
16. Мэдээлэл сонирхлын эрх ашгийг хамгаалах зорилготой хэмээн ангилж болох юм.

Тэгвэл эдгээр чиглэлийн төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаатай хамаарал бүхий төрийн яам, агентлугуудтай хэрхэн хамтарч ажиллаж байна вэ?, хэрвээ хамтарч ажиллаж байгаа бол нийгмийн салбарын ямар ямар асуудлыг хамтран шийдвэрлэж байна вэ? ,хэн энэ хамтын ажиллагааны үр шимийг хүртэж байна вэ ? монголын засгийн газар энэ хувь нэмрийг хэрхэн үнэлж ямар дэмжлэг үзүүлж байна вэ ? гэх мэт олон асуудлуудыг тооцоолж, судалж гаргаж ирэх хэрэгтэй болно. Ийм судалгаа, үйл ажиллагааг монголын төрийн болоод төрийн бус байгууллага, мэргэжлийн институт хийсэн үү? энэ судалгааны үр дүнг хэрэглээд гаргасан монгол улсын ямар ямар эрх зүйн баримт бичгүүд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна вэ? гээд олон асуудал шил шилээ даран гарч ирнэ.

Зарим ТББ-ууд урьд төр хариуцах ёстой гэж тооцогддог байсан нийгмийн салбаруудад идэвхтэй ажиллан, шинэчлэлийн явцад доголдож эхэлсэн нийгмийн үйлчилгээг нөхөх гэж оролдож байна.Гэвч ихэнх байгууллагууд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цөөхөн хэдэн байгууллага аймаг, хөдөө орон нутагт салбартай, шууд харилцаа холбоотой ажиллаж байна.

Бидний судалж мэдсэнээр хүүхэд залуучууд, жендер, гэр бүл, ахмадын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй ТББ-уудын үйл ажиллагаа илүү тогтмолжсон өргөн цар хүрээтэй байна.Энэ бүхний дотроос хүний хөгжил нөхөн үржихүйн эрүүл мэндийн (НҮЭМ) болон эмэгтэйчүүдийн байгууллагууд хамгийн

¹ Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Соросын сан) Монголын төрийн бус байгууллагуудын лавлах, Улаанбаатар хот, 2003 он

сайн зохион байгуулалт чадавхитай гэгддэг бөгөөд тэдний зарим нь нийлж сүлжээ, эвслийг амжилттай байгуулаад байна. Харамсалтай нь бусад ТББ-ууд ийм маягаар ажиллаж чадахгүй байгаа нь тэдний хувьд санхүүжилт, байрны асуудал хүнд байдаг бөгөөд бусадтай хамтран ажиллах чадвар, зохицуулалт зэрэг асуудал дутагдалтай байдгаас гадна өнөөдөр олон нийтийн дотор нийгмийн асуудлыг хамт олноороо, ямар нэгэн улс төрийн намын харьяалалгүйгээр шийдэж болно гэсэн ойлголт түгээмэл биш байгаатай холбоотой юм.¹ Олон улсын байгууллагын салбарын үүргийг гүйцэтгэдэг, бусад орны туршлагыг хэрэгжүүлдэг, эсвэл бусад орны байгууллагатай хамтарч ажилладаг ТББ Монголд харьцангуй цөөн байна.² Олон жилийн туршид тодорхой техникийн салбарт хуримтлагдсан олон улсын туршлага, ололт нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн үйл явцыг судлах байдал нэлээд хангалтгүй байгаа бөгөөд ихэнх тохисолдолд огт байхгүй байна. (Олон улсын хүний эрх гэх мэт асуудал)

1997 онд баталсан Төрийн бус байгууллагуудын хуулийг авч үзэхэд Парламент, Засгийн Газар ТББ-д маш нааштай хандаж байгааг харуулж байна. Уг хуулийн 4-р зүйлийн 1-д зааснаар ТББ гэдэг нь "төрөөс хамаарахгүйгээр өөрийгөө удирддаг, ашгийн төлөө бус, хувь хүмүүс болон төрийн бус хуулийн эрхийн байгууллагын сонирхол, үзэл бодол дээр суурилсан сайн дурын байгууллага юм" гэсэн байна. Хуулийн дагуу ТББ-ын үйл ажиллагаа явуулсан хөрөнгөд татвар ноогдуулахгүй бөгөөд ТББ-д хандив өргөсөн байгууллагуудын татварыг хөнгөрүүлэх заалт оржээ.³ Гэвч энэ заалт улс төрийн ямар нам эрх барьж байгаагаас, эсвэл хэн засгийн газрыг толгойлж байгаагаас хамааран тухай бүр өөр хуулийн заалтаар, эсвэл Гаалийн ерөнхий газрын дүрэм журмаар өөрчлөгдөж байдаг нь чадан ядан хөл дээрээ зогсох гэж байгаа зарим төрийн бус байгууллагууд гадаадаас бараа материал, эм хэрэгсэл, тоног төхөөрөмж хандивын журмаар оруулж ирэн, үйл ажиллагаа явуулахад нь ихээхэн дарамт шахалт болж байдгаас гадна гаднын донорууд өөрийн хамтран ажиллаж байгаа ТББ-ууддаа итгэх итгэл алдагдах магадлал ихтэй байдаг. Нөгөө талаас, жилийн өмнө төлөвлөгдөөгүй гэнэт бий болон гарч ирсэн гаалийн болон нэмүү өртгийн татварт төлөх шаардлагатай олон сая төгрөгийг нэмж олж авах гэж үндэслэл гаргах итгүүлэх асуудал нь ТББ-ын гүйцэтгэх захиралын ур чадварын асуудал болдог нь нууц биш юм. Асуудлын гол нь ТББ-ууд (ялангуяа гадаад орнуудаас санхүүжилт авдаг) төлөвлөгөөгөө жилийн өмнө хийж батлуулдаг бөгөөд энэ үед суулгаж өгөөгүй санхүүжилтийг дараа нь олоход хаана хаанаа бэрхшээлтэй байдаг нь ойлгомжтой. ТББ-ын хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд орон нутгийн зүгээс үнэлгээ хийх, хяналт тавих асуудал эхлэлийн төдий байдаг. ТББ-ын хуулийн дагуу, Засгийн газраас ТББ-ыг зөвхөн төсөл хэрэгжүүлэхэд л санхүүжүүлнэ гэж заасан нь Засгийн газар ТББ-ыг шууд санхүүжүүлэхгүй гэсэн үг юм. Ихэнх ТББ хаа нэгэн газраас, эсвэл төслөөс гадна өөрсдийн үндсэн үйл ажиллагаагаа явуулах хөрөнгийг олох асуудал бэрхшээлтэй байдаг нь бас нэгэн хүндрэлтэй асуудал юм. Үүнээс гадна ихэнх донорууд зөвхөн төсөл хэрэгжүүлэх санхүүжилт олгох бодлоготой байдаг байна. Засгийн газар нийгмийн салбарт үр дүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-уудыг тусгай шалгуураар сонгон наад зах нь байраар хангах асуудлыг тодорхой нэхцэлтэйгөөр авч үзэх хэрэгтэй байна.

¹ НҮБ-ын Хүн Амын Сан, Гурав дахь хөтөлбөр дэх ТББ-ын оролцоо

² НҮБ-ын Хүн Амын Сан, Гурав дахь хөтөлбөр дэх ТББ-ын оролцоо

³ Монгол улсын Төрийн бус байгууллагын тухай хууль, Дөрөвдүгээр бүлэг, 19-р зүйл, 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр

Бүсийнхээ олон орны нэгэн адил Монголын ТББ-ууд маш хязгаарлагдмал техникийн болон зохион байгуулалтын чадавхи(мөн туршлага), маш хязгаарлагдмал санхүүгийн нөөц бололцоотой байна.Тэд өөрсдийн боловсруулсан хөтөлбөр үйл ажиллагааг санхүүжүүлэх хандивлагчдыг идэвхтэйгээр хайж байна.Гэвч олон ТББ тогтмол цалинтай ажилтангүй алдаг оног төдий үйл ажиллагаа явуулж байна.(тэд голдуу урьд нь засгийн газарт ажиллаж байсан дунд болон дээд тушаалтнуудын сайн дурын туслалцаан дээр тулгуурлаж байна.)Зарим нэг хөл дээрээ тогтон ажиллаж байгаа ТББ нь орон тооны цөөн ажилтантай ажилтнуудын ажлын ачаалал их, байргүй, тоног төхөөрөмж болон бусад хэрэгсэл дутмаг байгаа бөгөөд өөрсдийн хэтийн зорилго, хэрэгжүүлэх хөтөлбөрийнхөө зорилтуудыг нарийн тодорхойлж чадахгүй байна.ТББ-ын өмнө тулгарч буй нэг гол асуудал бол тогтвор суурьшлын асуудал юм.

ТББ-ын ихэнх нь санхүүгийн эх сурвалж хомс, эрх зүйн орчин хязгаарлагдмал, үйл ажиллагаа нь нийтэд хүрч чадахгүй, туршлага багатай зэргээс шалтгаалж, ойрын ирээдүйд Засгийн газрын үүрэг, хариуцлагыг хуваалцана гэх итгэл төрүүлэхээргүй байна.Үүн дээр нийгмийн ялгарал хүчтэй болж, ядуурал нэмэгдэн, нийгэмд маш олон төрлийн эмзэг бүлэг бий болоод байгаа нь тэднээс тусгай техникийн тусламж авах хэрэгтэйг харуулж байна.

Гэвч ихэнх ТББ-ыг маш идэвхтэй, голдуу дээд ажилтнуудтай, эрдмийн зэрэгтэй гадаадын ТББ-ын туршлагыг судалсан хүмүүс удирдаж байгаа гэх мэтээр ТББ-ын чадавхи бүрдүүлэх төлөв харагдаж байгаа учраас Монголд ТББ-ыг үр дүнтэй, хэрэгцээт үйл ажиллагаанд ашиглах бололцоо байгаа нь тодорхой юм. Иргэний нийгмийн хөгжил өөрийн үүрэг бололцоог улам сайжруулж, нэмэгдүүлж байгаа учир ТББ нийгэмд өөрийн байр суурийг олж хүчирхэгжин, хөгжлийн явцдаа илүү үр өгөөжтэй, найдвартай хамтран зүтгэгч болох нь гарцаагүй юм.Олон янзын иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа ядуу, бололцоогүй хүмүүст тусалдаг байгууллагууд, гишүүддээ амьдралаа дээшлүүлэх, хөгжлийн үйл явцад оролцох, ардчилалыг бэхжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах бололцоог олгодог учраас, олон улсын хандивлагчдын зүгээс эдгээр байгууллагуудад дэмжлэг олгох бололцоотой байдаг байна.

Дараах үнэлэлт дүгнэлтийг төрийн бус байгууллагыг сонирхогч байгууллага хувь хүн доноруудад толилуулж байна.Үүнд:

- Монгол оронд ардчилал хөгжиж, иргэний нийгэм төлөвшиж буйг өнөөгийн ТББ-уудын үүсэл, төвхнөл харуулж байна. Судалгаанаас үзэхэд өнөөгийн ТББ-ууд нь “өсөлтийн” гэгдэх шатандаа “алдаа онооны” замаар урагшилж байна.Тийм ч учраас зорилго үйл ажиллагаа чиглэл нь тодорхойгүй байх, бүртгэл тооцоо сул, боловсон хүчний хангамж, тогтвор суурьшил хангалтгүй байх зэрэг өсөлтийн бэрхшээлүүд түгээмэл ажиглагдаж байна.
- Монгол оронд харьцангуй бсгино хугацаанд “Төрийн бус байгууллагын тухай хууль” батлагдангуут “дэлбэрэлтийн байдлаар” ТББ-ууд байгуулагдан үйл ажиллагаагаа өрнүүлж байна. Ийм “дэлбэрэлт” үүсэхэд донор орон, байгууллагуудын тусламж дэмжлэгээр хэрэгжүүлж буй Ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөр,Чөлөөт хэвлэл хөтөлбөр “Нэг ертөнц”,“Зайны сургалт” ,“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг төслүүд “өдөөгч” нь болжээ.
- Монгол улсад шинэ тулгар ТББ-ууд үүсч, хөл дээрээ тэнцэхэд нь НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, түүний хөгжлийн хөтөлбөр, Хүн

Амын Сан, ДАНИДА, ЖАЙКА Монголын Нээлтэй Нийгэм хүрээлэн, USAID зэрэг байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэсэн нь судалгаанаас харагдаж байна.¹

- Манай ТББ-ууд нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тусламж дэмжлэг авч шингээх чадвар сууж байгаа ч одоогийн шатанд тэд хэрэгжүүлэгч бус, харин идэвхжүүлэгч(сурталчилгаа, мэдэлэл, сургалт , судалгаа)-ийн үүрэг голлон гүйцэтгэж байна.
- Манай ТББ-ууд нь саявтархан үүсэн байгуулагдсан туршлага суугаагүй, бэл бэнчин тааруу, чадавхийн сул тул донор орон, байгууллагуудаас “хүлэмжийн нөхцөл ” шаардаж буйг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Дээрхи байдлаас үндэслэн дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

ТББ-уудыг нийгмийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн идэвхжүүлэгчийнхээс хэрэгжүүлэгчийн байр суурь, үүрэгтэй болгохын тулд нэгдүгээрт үйл ажиллагааных нь чиглэл хүрээг өргөжүүлж идэвхжүүлэх,хоёрдугаарт зохих тусламж, дэмжлэгийг донор орон байгууллагуудаас хүсэх хэрэгцээ шаардлага бодитой оршиж байна.

-Манай улсад, ялангуяа нийгмийн салбарт Монгол улсын Засгийн Газрын Нийгмийн Бодлогыг дэмжиж хэрэгжүүлэхүйц ТББ-ууд тооны хувьд бий болсоныг харгалзан “Засаглалын бүрэн эрх”-д хамаарахаас бусад чиг үүргийг ТББ-уудад зоримог бөгөөд дэс дараатай шилжүүлэх

-Засгийн газрын төсөл, захиалгын тендэрийг улам ил тод, олон гарц, орцтой болгох

-Засгийн газрын хөтөлбөр, төсөл, захиалгад оролцох, гүйцэтгэх,хэрэгжүүлэх шатанд өрсөлдөөнийг бий болгох, тэгэхдээ ТББ-ууд шударга, ижил нөхцөлд өрсөлдөх эрх зүйн орчныг бүрдүүлэх

-Төсөл хэрэгжүүлж буй ТББ-уудыг эрсдлээс хамгаалах даатгалын санг Засгийн газар бүрдүүлэх

-Төсөл хөтөлбөрийг гол төлөв санхүүгийн эх үүсвэрээр нь бус үр дүн, өгөөжөөр нь үнэлдэг, дүгнэдэг шалгуурт аажмаар шилжих

-ТББ-уудад “хүлэмжийн нөхцөл ” бүрдүүлэх чиглэлээр биш, харин тэдгээрийн чадавхийг дайчлах чиглэлээр гадаад,дотоодын хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг, тусламж үзүүлэх

-ТББ-уудын мэдээллийн санг тэдгээрт бус нийгэмд хүртээх чиглэлээр бүрдүүлэх

-ТББ-уудын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа олон нийт, ТББ-уудын өөрсдийнх нь саналыг авч тусгах, Засгийн газрын нийгмийн салбарын зорилт, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхүйц ТББ-уудыг үүсгэн байгуулах тэтгэн дэмжихийн хамт ТББ-уудад “мөнгө угаах”, татварааё зайлсхийхдүрмийн бус үйл ажиллагаа явуулах үүд хаалгыг хаах асуудлыг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үед анхаарах

-Засгийн газрын одоогийн хуулийн хүрээнд янз бүрээр эрэмблэгдэж ,ямдад өөр өөрөөр харьяалагдаж буй байгууллага, газруудад хүртэл ТББ-уудыш үйл ажиллагааг нээлттэй болгох,Тухайлбал Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэхээр гэрээлэх хэлбэрт шилжүүлж,нийгмийн үйлчилгээний салбарын улсын байгууллагуудын монополь шинжийг задлах

¹ “Төрийн бус байгууллагуудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн судалгаа” UNDP, Удирдлагын академийн зөвлөлгөө, Бизнесийн төв, зохистой хөгжлийн жөндөр төв, Улаанбаатар хот, 2000 он

зардлаа тооцож , чанараа сайжруулах замаар үйлчилгээний захиалга олж авахын төлөө өрсөлдөөнийг хөгжүүлэх

-Томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ-уудын нөөц чадавхийг төвлөрүүлэхийн хамт тэдгээрийн дундаас толгойлогч-зохицуулагч байгуулагын чадавхийг гол үзүүлэлт болгон шалгаруулж ажиллуулах

-ТББ-уудын талаар багц үзүүлэлтийг үндэсний статистикийн эмхтгэлд суулгаж , нийтийн хүртээл болгох зэрэг болно.

-“Төрийн бус байгууллагуудын тухай” Монгол улсын хуулийг олон улсын өргөн цар хүрээтэй сүлжээнд ТББ-ууд хамрагдаж байгаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна .